

## Э.Чойдогийн “Шарилжин дундах цэцэг” балетын Адажио-г хөгжимдөх үйл явц дахь концертмейстерийн үүрэг

**Болдын Гэрэл** ✉

Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ [gerel\\_bld@yahoo.com](mailto:gerel_bld@yahoo.com)

**Нацагийн Жанцанноров**

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Дашнямын Ариунаа**

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Хураангуй:** Балетын концертмейстерээр мэргэшсэн төгөлдөр хуурчид манай улсад цөөн бөгөөд хамсран хөгжимдөх ажил үүргийн хувьд гоцлоочдоос ихээхэн ялгаатай байдаг. Балетын концертмейстер нь бүжгэн жүжигт хамсран хөгжимдөхдөө гол дүрүүд тус бүрийн зан төрхийг тодотгон, ур чадварын өндөр түвшинд, бүжигчний үйл хөдөлгөөнийг нарийн мэдэрч, агуулгатай уялдуулан хөгжимдөх онцлогтой. Иймд хамсран хөгжимдөгчийн гүйцэтгэл дэх хөгжим, бүжгийн харилцан холбоо, хамсраа хөгжимдөлтийн онцлогийн талаар ажиглалт хийхийг зорьсон болно.

Төрийн шагналт, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн “Шарилжин дундах цэцэг” балет нь Урангуа, Галт, Ширүүнгарьд, Зэвт гэх гол дүрүүдтэй бөгөөд Галт, Урангуа нарын хайрын Адажио-ийн гол сэдэв аялгуу нь өргөн дуулалтай, сэтгэлийн гүн гүнзгий мэдрэмжийг төрүүлдэг билээ. Ингээд “Шарилжин дундах цэцэг” балетын 3-р үзэгдлийн Галт, Урангуа нарын Адажио-д балетын концертмейстерийн хөгжимдөх арга зүйн талаар ажиглалт хийснээ энэхүү өгүүлэлдээ тусгасан болно.

**Түлхүүр үгс:** *хөгжим, балет, хамсран хөгжимдөгч, хослол бүжиг*

## The role of the accompanist in the performance process of the Adagio from the ballet “The Flower among the Wormwood” by E.Choidog

**Gerel Bold** ✉

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia  
✉ gerel\_bld@yahoo.com

**Jantsannorov Natsag**

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

**Ariunaa Dashnyam**

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** There are relatively few pianists in our country who specialize as ballet concertmasters, and their collaborative role differs significantly from that of solo performers. A ballet concertmaster must highlight the characters of the principal roles, perform at a high artistic level, and closely sense the dancers’ movements while integrating the music with the dramatic content. This study therefore focuses on observing the relationship between music and dance and the characteristics of collaborative performance. The ballet “*The Flower Among the Wormwood*” by composer E. Choidog features the main characters Urangua and Galt, whose Love Adagio is notable for its broad, lyrical theme and deep emotional expression. This article examines the performance approach of the ballet concertmaster in the Adagio from the third scene of the ballet.

**Keywords:** *music, ballet, concertmaster, adagio*

### Оршил

Ц.Нацагдоржийн цомнол, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн “Шарилжин дундах цэцэг” /1965/ балет нь УДБТеатрын тайзнаа тавигдсан үндэсний анхны бүжгэн жүжгийн бүтээл болсон юм. Энэхүү балетыг анхны тавилт дээр хөгжмийн зохиолч Э.Чойдог, ерөнхий найруулагч, балетмейстер Б.Жамъяндагва, зураач Л.Гаваа, удирдаач Ж.Чулуун, туслах найруулагч Г.Батсүх, зөвлөлтийн мэргэжилтэн, концертмейстер В.Н.Гельфер нар ажиллажээ. Хожим нь 1987 онд энэхүү бүтээлд бүжиг дэглэлтийн талаас дахин шинэчлэлт хийгдсэн боловч хөгжмийн тал дээр ямар нэгэн өөрчлөлт ороогүй юм. “Шарилжин дундах цэцэг” нэг бүлэгтэй авсаархан боловч манай бүжгийн жүжгийн хөгжимд цоо шинэ алхам хийсэн (Жанцанноров 2007, 121).

“Шарилжин дундах цэцэг” балетад монголын бага хаадын үеийн баатруудын эмгэнэлт хайрын түүхийг өгүүлдэг бөгөөд 1 бүлэг, 3 үзэгдэлтэй. Балетын гол дүрүүд нь үзэсгэлэнт бүсгүй Урангуа, түүний сэтгэлт залуу Галт, цэргийн захирагч Ширүүнгарьд болон туслах Зэвт нар болно (Жамъяндагва 2012, 7). “Шарилжин дундах цэцэг” балетын 2-р үзэгдлийн Галт, Урангуа нарын Адажио-д балетын

концертмейстерийн хөгжимдөх арга зүйн талаар ажиглалт хийснээ та бүхэнд танилцуулж байна.

Адажио гэдэг нь италиар *Adagio* буюу удаан, тайван гэсэн утгатай үг бөгөөд хөгжимд хоёр утгаар хэрэглэгддэг. Үүнд: 1-рт, хөгжмийн зохиолын хурдыг илэрхийлсэн нэр томьёо, 2-рт, тайван, удаан шинж бүхий жижиг хэлбэрийн дан хөгжмийн аяз байдаг. Харин балетад *Adagio* нь бүжгийн утга уянгын шинжтэй зохиомж, хослол бүжиг буюу хөгжмийн хамгийн уянгын хэсэг, гол дүрүүдийн хайр сэтгэлийн илрэл болсон хосуудын удаан, уянгалаг өнгө аястай бүжиг юм (СУИС 2018, 2). Балетын гол дүрд бүжиглэх эмэгтэй бүжигчний гоёмсог, уян налархай байдлыг харуулсан бүжиглэлтийг эрэгтэй бүжигчин өөрийн хүч чадал, эрэмгий байдлаар дэмжиж, тэнцвэртэй байдлыг харуулан бүжиглэдгээрээ онцлогтой.

### **Судалгааны онол, арга зүй**

Э.Чойдогийн “Шарилжин дундах цэцэг” балетын Адажио-оор жишээлэн балетын концертмейстерийн хөгжимдөх ур чадварын асуудлыг судлан тодруулахдаа, нэгдүгээрт, балетын Адажио хэсгийн талаарх онолын ойлголтыг өгөх, хоёрдугаарт, Адажио-г төгөлдөр хуураар хөгжимдөхөд концертмейстерийн гүйцэтгэлийн онцлог, ур чадварт ажиглалт хийх, бүжгийн хөдөлгөөн, уян хатан чанарыг хэрхэн бүжигчний амьсгаатай уялдуулах зэрэг төгөлдөр хуурчийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох утга тайллын /герменевтик/ арга, гуравдугаарт, концертмейстерийн гүйцэтгэл дээр тулгуурлан түгээмэл бэрхшээлүүдийг илрүүлэх зэргээр авч үзэв.

### **Судалгааны үр дүн**

Гадаад улс орнуудад балетын хөгжмийн тухай судалгааны ажлууд олон бий. Тухайлбал, ОХУ-д Г.Безуглая “Новый концертмейстер балета” (2017) номд балетын концертмейстерийн үүрэг, ур чадварын онцлог, балетын хөгжимтэй хэрхэн ажиллах талаар, Ю.Г.Куна “Курсы подготовки концертмейстеров балета: Учебно-методическое пособие” (2005), В.Н.Холопова “Музыка как вид искусства” (2002), Л.Н.Лысцова “Об отечественной теории и практике обучения концертмейстеров балета за рубежом (на примере Пермского колледжа)” (2013), Т.Г.Мельникова “Проблемы формирования профессиональной культуры концертмейстера балета” (2016) номд балетын хичээлийн бүтэц, хөгжмийн материалын сонголт, балетын хөгжмийн хэмнэл, концертмейстерийн үүрэг, хөгжимдөх арга барилын талаар тус тус өгүүлжээ.

Монгол Улсад балетын урлагийн үүсэл гарал, уламжлал, бүтээл туурвил, урын сан, уран бүтээлчдийн намтрын талаарх судалгааны ажлууд нэлээд бичигдсэн байна. Тухайлбал, Ж.Жав “Монголын балетын урлагийн хөгжил” (1983), Б.Жамъяндагва, Д.Лхагвасүрэн “Тавин балетын либретто” (2012), С.Дашдондог “Хөгжим, дуурь, балет судлал” (2013), Г.Барбаатар “Бүжиг бол ухааны урлаг” (2020) бүтээлд “Шарилжин дундах цэцэг” балетын түүх, цомнол, дэглэн найруулах арга барил, уламжлал, шинэчлэл, уран бүтээлчдийн намтар, ярилцлага, уран бүтээлүүдийн шүүмж, Н.Жанцанноров “Хөгжим цаг үе” (2006), “Миний л харгуй” (2019), “Монгол хөгжмийн арван хоёр хөрөг (сонатын аллегро)” (2007), М.Ундраа “Эрэгзэнгийн Чойдог” (2022) номд хөгжмийн зохиолчийн бүтээлийн судалгаа,

хөгжмийн зарчим, намтар, түүхээс судалсан бол, У.Цэцэгмаа “Концертмейстер” (2003) номд монголын концертмейстерийн урлагийн үүсэл хөгжил, төрөл зүйл, концертмейсерийн ур чадвар, үйл ажиллагаа, арга туршлагаас судлан бичжээ. Энэ ном нь өдгөө монголын төгөлдөр хуурч, концертмейстерүүдэд анхдагч судалгааны эх хэрэглэгдэхүүн болж байна.

Урангуа бол гоо үзэсгэлэнт, даруу төлөв, нинжин сэтгэлтэй харц бүсгүй, харин Галт нь цэргийн жанжин Ширүүнгарьдын ойрын туслах бөгөөд уян зөөлөн сэтгэлтэй, монгол хүний сайхан зан чанаруудыг шингээсэн, эрэлхэг залуу баатар эрийн дүр юм. “Шарилжин дундах цэцэг” балетын 3-р үзэгдэл дэх Галт, Урангуа нарын Адажио буюу хайр сэтгэлийн нь илэрхийлэл болсон хосын бүжгийн хөгжим нь Си минорын хөг эгшиглэгээнд, 2/4 хэмжээтэй, *largo* буюу тэнүүн удаан байдаг. Уг Адажио нь давтах хэсэг өөрчлөлттэй, энгийн гурван хэсэгт хэлбэрт бичигдсэн бөгөөд гол сэдэв аялгуу нь өргөн дуулалтай, хайр сэтгэлийн гүн гүнзгий мэдрэмжийг илтгэсэн өгүүлэмжтэй. Хөгжим нь байгалийн сайханд хайр сэтгэлдээ умбан буй хосуудын аз жаргалтай байдлыг илтгэх ба жигд хэмнэлтэй, арван зургаатын хэмжээтэй эгшгүүдийн давлагаалсан дараалалтай эгшгүүд босоо ятгаар уянгын тайван шинжтэй дөрвөн айзам оршлоор тэгшхэн, зөөлөн сонсогдоно.



Зураг 1. Галт, Урангуа нарын Адажио, оршлын 4 айзам

1-р цифрийн гол сэдэв аялгуу нь Галт, Урангуа хоёрын хайр сэтгэлийг илэрхийлэх ба давтагдсан 2 өгүүлбэртэй үе хэлбэрт бичигдсэн, эмэгтэй хүний уян зөөлөн өнгө аястай, монгол ардын дууны шинжтэй байна.

Адажио-ийн эхэнд морин хийлээр тоглох гол сэдэв аялгуу уянгын бөгөөд зөөлөн намуухан өнгө аястай босоо ятгын хамсраанд суурилан уянгална. Эмэгтэй хүний гоёмсог, уян налархай байдлыг харуулсан *arabesque* буюу ажиллагч хөл хойшоо чиглэлд өргөгдсөн байх (Онон 2020, 10) хөдөлгөөнийг бүжигчин хийж гүйцэтгэхэд, эрэгтэй бүжигчин нь түүнийг дэмжиж, тэнцвэртэй байдлаар бүжиглэдэг. Энэ хэсэгт хэрэв яарч хөгжимдвөл бүжигчдийн хөдөлгөөний тэнцвэр алдагдаж, гүйцэтгэлийн чанар муудах тул бүжигчдээ харж нэгэн зэрэг амьсгаатай тайван, холбоостой хөгжимдөх учиртай. Энэ хэсэгт залган эмэгтэй бүжигчний *soutenu* ба хоёр хөлийг цуглуулах (Онон 2020, 93) гэсэн хөдөлгөөнд хөгжмийн хэмнэлийг бага зэрэг татасхийж, баруун гарт тоглогдох аялгууны чимэглэл, нугалааг сунган хурдыг татаж тоглоно.



Зураг 2. Гол сэдэв аялгууны эгшиглээс

2-р цифрийн туслах сэдэв аялгуу мөн адил давтагдсан хоёр өгүүлбэртэй үе хэлбэрт бичигдсэн. Эмэгтэй бүжигчин нь *developpe* буюу хөдөлгөөнийг хөгжүүлэх (Онон 2020, 43) *gran developpe* буюу том хэлбэрээр хөдөлгөөнүүдийг гүйцэтгэх бөгөөд хөгжмийн хувьд мөн адил уянгын тайван, морин хийл хөгжмийн эгшиглээг тодруулан хөгжимдөх нь чухал юм.



Зураг 3. Туслах сэдэв аялгууны эгшиглээс

Туслах сэдэв аялгуу хөгжсөнөөр реприз буюу давтах хэсэгт /А/ хүргэдэг. А хэсгийн давталтад экспозицийн хэсгийн үндсэн сэдэв аялгуунууд өмнөх дарааллаар давтагдахдаа хам эгшгүүдийн хамсраатай болон өргөжиж, илүү тод томруунаар дуурьсана. Сэдэв аялгууны эгшиглээ морин хийлээс аажмаар альт хөгжмийн гоцлол руу шилжин үргэлжилнэ. Бүжгийн хөдөлгөөний хувьд *gran arabesque*, стульчик буюу сандал гэж нэрлэгддэг том өргөлтүүдийг гүйцэтгэдэг бөгөөд залуу баатар Галт хайраа илэрхийлж байгааг дүрсэлдэг. Энэ хэсгийг хөгжимдөхдөө зүүн гарын арван зургаат хэмнэлүүдийг аажмаар удаашруулан татасхийж хөгжимдөх бөгөөд сэдэв аялгууг яаран эхлэхгүй, бүжигчдээ анхааралтай харж, эмэгтэй бүжигчин том арабеск ба сонгодог бүжгийн үндсэн барилуудын нэр (Онон 2020, 10) хөдөлгөөнийг гүйцэтгэн эрэгтэй бүжигчний мөрөн дээр суух мөчид л зэрэг тоглох учиртай юм.



Зураг 4. Хөгжүүлэг хэсэг

Цифр 5-аас холбоос хэсэг эхлэх ба жүжиглэлт улам өрнүүн болж хурдын хувьд хөгжим нь эхнийхийг бодвол бага зэрэг урагшилж, Галт, Урангуа нар аз жаргалтайгаар тойрон гүйлдэх бөгөөд эмэгтэй бүжигчний *шене* буюу гинжин эргэлтэд баруун гарт тоглогдох арван зургаат хэмнэлүүдийн хөгжимдөлтийг жигд тоглох хэрэгтэй.



Зураг 5. Жүжиглэлт улам өрнүүн болох хэсэг

Цифр 6-ын 10-р айзамд хөгжим нь харшаа хам эгшгүүдээр илэрхийлэгдэх бөгөөд гэнэт чимээ гарах үед хосууд сэрдэхийн ийш тийш харсан ч бүх зүйл тайван байгааг хараад тайвшран аз жаргалдаа умбан бүжиглэнэ. Энэ үед концертмейстерийн хөгжимдөх хэсэгт баруун гарт ноотуудын “акцент” буюу цочир өргөлт зэрэг хөгжимдөх янз маягийн ялгааг тодорхой гаргах хэрэгтэй.



Зураг 6. Хосуудын цочин, сэрэмжлэх хэсгийн эгшиглээс

Холбоос хэсгээс өрнүүлэг **B** хэсэгт хүргэдэг. Энэ хэсэг нь *Allegro* хурдтай ба  $\frac{3}{4}$  хэмжээтэй бичигдсэн бөгөөд хүчдэлийн хувьд фортиссимо /*ff*/ болж нэмэгдэнэ. Хөг эгшиглэгээний хувьд тод ялгарамжтай байхын зэрэгцээ хамсрааны галбиршил өөрчлөгдөн эхний хэсгийн адил давлагаалсан онцгой хэмнэлүүд болох секстольууд орж ирнэ. Энэ хэсгийг тусгаар хэсэг /эпизод/ гэж үзэх бүрэн боломжтой бөгөөд дунд хэсгийн хөгжим эрс ялгарамжтай биеэ даасан хөгжүүлэгтэй үе хэлбэрт /*A*/ бичигдсэн.



Зураг 7. Галт, Урангуа нарын хайрын өрнүүлэг хэсгийн эгшиглээс

Дүрслэлийн хувьд Галт, Урангуа нарын хайр сэтгэлээ илэрхийлэх үйл явцын өрнүүлэг хэсэг болох бөгөөд хослон бүжигчид дунд өргөлтүүдийг хийж гүйцэтгэдэг. Энэ хэсэгт концертмейстер нь баруун гарт *ff* чанга, хүчтэй тэмүүлэлтэй хөгжимдөх хэрэгтэй болно. Гэвч хүчтэй тоглоно гэхээр балбаж нүдэж тоглож болохгүй юм.

В хэсгийн төгсгөлд холбоос хөгжим 16 айзам үргэлжлэх бөгөөд хосууд тоглон бүжиглэх дүр зургийг харуулна. Хөгжимд наймт хэмжээтэй эгшгүүдээр уруудсан аялгуунд бүжгийн баланс ба ганхсан хэсэг, биеийн жинг нэг хөлөөс нөгөө хөлд шилжүүлэх (Онон 2020, 19) болон гинжин эргэлт зэрэг эргэлтийн хөдөлгөөнд хурдыг бага зэрэг татаж, модон үлээврүүдийн онцлог эгшиглээнд аялгууг жигдхэн, тэгш хөгжимдөнө.



Зураг 8. Холбоос хөгжмийн эгшиглээ

**A1** буюу өөрчлөлттэй давтах хэсэгт Галт Урангуа нарын оргилсон их хайр, аз жаргалтай байдлыг дүрсэлдэг. Төгсгөлийн А хэсгийг эхний хэсгийн хэмжээтэй харьцуулахад харьцангуй богино нийт 24 айзам байх бөгөөд хөгжмийн илэрхийлэмж нь огшсон, хураангуйлсан шинжтэй байдаг. Хөгжмийн бүтцийн хувьд энэ хэсэг нь үе хэлбэрт бичигдсэн бөгөөд эхний хэсгийн сэдэв аялгуу давтагдаж байгаа боловч хурдын хувьд ижил, хүчдэл нь *f*, хам эгшгийн хамсрааны хэлбэршил нь өөрчлөгдсөн байна. Зүүн гарт гучин хоёрт хэмнэлээр дуржигнуулгатай, аялгууны хувьд хам эгшгүүдээр давхар эгшиг болон наймцаар хослон эгшиглэх бөгөөд энэ үед Адажио-ийн оргил хэсэг өрнөнө. Хослон бүжигчдийн ур чадварыг харуулсан хамгийн том өргөлт болох хараацай, том *assemble* буюу цугларах (Онон 2020, 13) хайчлах үсрэлтийг гүйцэтгэх бөгөөд концертмейстер нь зайлшгүй бүжигчдээ харж нэгэн амьсгаатай хөгжимдөх нь маш чухал юм.

Энэ хэсэгт найрал хөгжим бүрэн бүрэлдэхүүнээрээ *Tutti* тоглох бөгөөд үүнийг хөгжимдөхдөө сэдэв аялгууг тод, зүүн гарын дуржигнуулгыг тасралтгүй жигд хөгжимдөх шаардлагатай болно.



Зураг 9. Найрал хөгжим бүрэн бүрэлдэхүүнээрээ *tutti* тоглох хэсэг

Төгсгөлийн хэсэгт хурдыг татаж, хүчдэлийн хувьд маш хүчтэй буюу *fff* нүргэлэх хам эгшгүүдээр 9 айзам үргэлжилж төгсөнө. Галт Урангуад хайраа дахин дахин илэрхийлэн бүжиглэхдээ том үсрэлтүүдийн техникийг үзүүлэх бол эмэгтэй бүжигчин нь уян зөөлөн *arabesque*, унах хөдөлгөөнийг хийж энэ хэсэг төгсдөг. Эрэгтэй бүжигчин булангаас *ra de chat* буюу муурын алхам (Онон 2020, 69) гэх үсрэлтээр үсрэх тул үүнийг хөгжимдөхдөө бүжигчнээ харж нэгэн амьсгаатай тоглоно.



Зураг 10. Эрэгтэй бүжигчин булангаас *ra de chat* үсрэх хэсгийн эгшиглээс

Энэ бүхнээс ажиглалт хийж үзвэл, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн “Шарилжин дундах цэцэг” балет нь монголын үндэсний балетын нэгэн шилдэг туурвил бөгөөд балетын үзэгдэл бүрд үзэсгэлэнт байгалийн дүр төрх, хайр сэтгэл, уян зөөлөн аяс, зөрчил тэмцэл дүрслэгддэг. Ялангуяа Галт Урангуа нарын Адажио-оор хүн төрөлхтний мөнхийн сэдэв болох хайр дурлалыг хөгжмийн гайхамшигтай аялгуугаар, үйл явдлыг симфони өрнөлөөр илэрхийлж, дүр бүхэнд онцлог аялга, хөгийг оногдуулснаараа өвөрмөц болжээ. Ийм ч учраас бүжгэн жүжгийн концертмейстерүүд тухайн бүтээлийнхээ өгүүлэмж дэх үзэсгэлэнт байгаль, хайр дурлал, зөрчил тэмцэл төдийгүй, ерөөс хөгжмийн агуулгыг гүйцэд илэрхийлэн найрал хөгжмийн дайтай, хөгжим ба бүжгийн харилцан хамаарлыг сайтар мэдэрч хөгжимдөх шаардлага тулгардаг билээ.

### Хэлэлцүүлэг

Балетын концертмейстерийн хөгжимдөх ур чадварыг судлах нь бүжгийн агуулга, уран сайхны нэгдлийг хангах, хөгжмийн илэрхийллийг бүтээлд шингээх гол хамсрагч болох нь судалгаанаас харагдаж байна. Концертмейстер нь жүжгийн утга санаа, дүрүүдийн зан төрхийг тодотгон чадварлаг хөгжимдөх нь бүжигчдэд дүрийн утгыг ойлгуулах, хурд, хүч зэрэг хөдөлгөөний гүйцэтгэлийн ур чадварт ихээхэн нөлөөлдөг байна. Иймээс балетын концертмейстерийн ур чадварын түвшнийг дээшлүүлэх, ирээдүй залуу төгөлдөр хуурчдад энэ чиглэлээр ажиллахад нь заан сургах, хичээлийн хөтөлбөрт арга зүйн зөвлөмж боловсруулах нь нэн шаардлагатай бөгөөд энэ сэдвээр тусгайлан авч судлах нь чухал юм.

## Дүгнэлт

“Шарилжин дундах цэцэг” балетын Галт, Урангуа нарын Адажио-г хэрхэн хөгжимдөх талаар авч үзэн ажиглалт хийснээр дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Хөгжмийн зохиолч Э.Чойдог нь энэхүү балетдаа сонгодог балетын хөгжмийн зохиомжийн арга барилын уламжлалыг монгол хөгжмийн аялгаар баяжуулж, арфа хөгжмийн хамсраатай морин хийлийн гоцлолыг оруулсан нь уг балетын хөгжимд босоо ятгын онцлог дуугаралт бүхий оноот эгшиглээ болжээ.
2. Галт, Урангуа нарын хоршил бүжиг буюу Адажио-д бүжигчний дүрээ илэрхийлэх үсрэлт, эргэлт хөдөлгөөний хэмнэл, хэв шинжийг концертмейстер нь хөгжмийн аялгуу, хэмнэл, штрих, хурд зэргийг хөгжмийн өгүүлэмжээрээ сайтар тодотгож өгөх нь чухал. Үүний тулд энэхүү Адажио бүжигт орсон *шене, soutenu, arabesque, developpe, gran developpe, pa de chat* болон хамгийн том өргөлт болох хараацай, том *assemble*, хайчлах үсрэлт зэрэг үсрэлтийн техникүүдийн үргэлжлэх хугацаа, хурдыг маш сайн мэдэж мэдрэх хэрэгтэй болдог.
3. Галт, Урангуа нарын хоршил бүжгийн дүр бүхэнд өвөрмөц аялга, хөгийг оногдуулснаараа ихээхэн онцлогтой болжээ.
4. Хөгжмийн зохиолч Адажио-ийн энэ хөгжимд хөдөлгөөнийг утгажуулан, хөгжмийн найруулгыг хийхдээ хөгжмийн драматургаар бүжгийн утга санааг тодорхой үзүүлснийг концертмейстерийн зүгээс анхаарч хөгжимдөх хэрэгтэй хэмээн дүгнэлээ.

### Ашигласан материалын жагсаалт

- Безуглая, Г.А. 2018. *Новый концертмейстер балета*. Санкт-Петербург: Планета Музыка.
- Жамъяндагва, Балжинням. 2012. *Тавин балетын либретто*. Улаанбаатар: Хүслийн өнгө.
- Жанцанноров, Нацаг. 2007. *Монгол хөгжмийн арван хоёр хөрөг*. Улаанбаатар: Admon.
- Онон, Гомбосүрэн. 2020. *Сонгодог бүжгийн нэр томъёоны товч тайлбар толь*. Улаанбаатар: Мелон ХХК.
- Соёл урлагийн их сургууль. 2018. *Соёл урлагийн тайлбар толь, Цуврал V: "Бүжиг"*. Ред. Сонинтогос Э. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Цогтгэрэл, Шальш. 2021. *Хөгжмийн төрөл зүйл, хөгжмийн зохиолуудын нэршлийн тайлбар*. Улаанбаатар: Дэвшил дизайн ХХК.

### Ярилцлага:

Д.Алтантуяа (балетын ахмад жүжигчин)-тай хийсэн ярилцлага. Улаанбаатар, 2024

Г.Онон (балетын ахмад жүжигчин)-той хийсэн ярилцлага. Улаанбаатар, 2024